



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 1189

Мандалговь


「Газар эзэмших эрхийн гэрчилгээний төсөл」  
сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 33.1.2 дах заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалт явуулах журам, Сайнцагаан сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт /Тэспетролиум ШТС-ын зүүн урд талд /900 м.кв /0,09 га/ газрыг үйлчилгээний зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээг төсөл сонгон шалгаруулалтаар иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшилд олгосугай.

Хоёр. Төсөл сонгон шалгаруулалтыг явуулах хугацаа, тавигдах шаардлага, нөхцлүүдийг тодорхойлон нийтэд зарлан мэдэгдэж, хэрэгжүүлэх ажлыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200576